



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/109

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож,
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.3, 46.1.6 дахь хэсгүүд, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн А/11 дугаартай захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сан дахь зураг төслийн сангийн хөрөнгө оруулалтаар Жанхайн даваан дээр орон нутгийн иргэдийн худалдаа үйлчилгээ, явуулах боломжийг бүрдүүлсэн тохижилт бүхий цэг байгуулах ажлын зураг төсөл боловсруулах ХӨАОНӨГ/202302103 дугаартай зөвлөх үйлчилгээ 7,931,000 (Долоон сая есөн зуун гучин нэгэн мянган) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Редсан” ХХК-ийн саналыг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. Аймгийн орон нутгийн хөгжлийн сан дахь зураг төслийн сангийн хөрөнгө оруулалтаар Жанхайн даваан дээр орон нутгийн иргэдийн худалдаа үйлчилгээ, явуулах боломжийг бүрдүүлсэн тохижилт бүхий цэг байгуулах ажлын зураг төсөл боловсруулах зөвлөхтэй байгуулсан гэрээг удирдах, зураг төсөл хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн ерөнхий архитектор)

Гишүүд: Б.Энхжаргал (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Минжүүржаргал (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн)

3. Гэрээний хэрэгжилтийг хангах, гэрээг дүгнэх, зураг төсөл хүлээн авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Даваасүрэн)-д, Захиалагч, тендерт оролцогчийн тендерийн баримт бичиг, үнийн саналыг үнэлж шийдвэрлэсэн баримт бичиг, гэрээний хэрэгжилтийг үнэлсэн баримт бичиг, зураг төсөл хүлээн авсан акт, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг баримт бичгийг архивын нэгж болгон архивд шилжүүлэхийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Б.Минжүүржаргал)-д тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

d/zahiramj
671 010468